



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

С.Зоригийн гудамж 2, 1 дүгээр хороо
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976) 7711 1027, Цахим шуудан: info@fchm.edu.mn

2026.08.27 № 1/1539
танай _____-ны № _____-т

Үнийн санал авах тухай

Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн кибер аюулгүй байдал, дотоод сүлжээний найдвартай хэвийн ажиллагааг хангаж ажиллахын тулд Fortinet FortiGate 200f (Firewall) төхөөрөмжийн лицензийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу үнийн санал ирүүлнэ үү.

Үнийн саналыг 2026 оны 09 дүгээр сарын 02-ны 16:00 цаг хүртэл хүлээн авна.

Мэйл хаяг: procurement@fchm.edu.mn

Хаяг: УНТЭ-ийн 5 давхар.

Хавсралт 1 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



П.АНХТУЯА

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий
захирлын 2026 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн 1/1536 дугаар албан бичгийн хавсралт



Лиценз шаардлагатай тухай үндэслэл

• Аюулгүй байдлын шинэчлэлт зогсох (FortiGuard): Кибер халдлага, вирус, хортой кодууд секунд тутамд шинэчлэгдэн гарч байдаг. Лицензгүй үед галт хана шинэ төрлийн халдлагуудын датаг (Signatures) хүлээж авч чадахгүй тул сүлжээ хамгаалалтгүй болно.

• Ухаалаг шүүлтүүрүүд идэвхгүй болох: Вэб шүүлтүүр (Web Filtering) болон Аппликейшн хяналт (Application Control) ажиллахаа болино. Ингэснээр ажилчид фишинг (хуурамч) вэб сайт, хортой холбоосууд руу санамсаргүй нэвтэрч дотоод сүлжээнд вирус тараах нөхцөл бүрдэнэ.

• Халдлагаас хамгаалах систем (IPS) зогсох: Гадны хакеруудын халдлага болон серверийн цоорхойг ашиглах үйлдлүүдийг илрүүлж хаах функц идэвхгүй болж, байгууллагын нууц мэдээлэл алдагдах эрсдэл үүснэ.

• Үйлдлийн системийн шинэчлэлт (FortiOS): Системийн дотоод алдаа болон аюулгүй байдлын чухал цоорхойнуудыг нөхөх программ хангамжийн (Firmware) шинэчлэлтүүдийг татах эрх хаагдана.

• Инженерийн дэмжлэг хаагдах (FortiCare): Системд ямар нэгэн доголдол эсвэл тохиргооны хүндрэл гарахад үйлдвэрлэгчийн албан ёсны 24/7 техникийн тусламж авч чадахгүйд хүрнэ. Хэрэв төхөөрөмж шатах зэрэг техник хангамжийн гэмтэл гарвал баталгаат солилцоо (RMA) хийгдэхгүй.

Техникийн тодорхойлолт

Төхөөрөмжийн сериал дугаар - FG200FT923904880

- Нийлүүлэх барааны техникийн тодорхойлолт нь дараах стандарт шаардлагад нийцсэн байна.
- Албан ёсны үйлдвэрлэгчээс олгосон нийлүүлэх эрхийн гэрчилгээг хавсаргана.

№	Төхөөрөмж	Part number	Тоо ширхэг/ төрөл	Хугацаа	Тайлбар
1	UTP Bundle	FC-10-F200F-950-02-36	1 /сунгалт	2026 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал	FortiGate-200F Unified Threat Protection (UTP) (IPS, Advanced Malware Protection, Application Control, URL, DNS & Video Filtering, Antispam Service, and FortiCare Premium) FortiGate